



Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны хийсэн ажлын бичмэл тайлан

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын Ерөнхий газрын 2024 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн А/51 дүгээр тоот тушаалаар 3 хэлтэс, 1 тасаг 45 орон тоотойгоор батлагдсан. Одоогийн байдлаар Захиргаа, хяналтын хэлтэс, Санхүү бүртгэл, хамралт орлогын хэлтэс, Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс, Бор-Өндөр суманд нийгмийн даатгалын үйлчилгээний нэг тасаг 37 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Нийт ажилтнуудын 17% хувь нь эрэгтэй, 83% нь эмэгтэй ажилтнууд байна. Удирдах ба чиг үүрэг хэрэгжүүлэх, туслах албан хаагчдын 90.7% хувь дээд боловсролтой. Албан хаагчдын дунд магистр зэрэгтэй албан хаагч 3, бакалавр зэрэгтэй албан хаагч 32 байна.

Боловсролын байдал

№	Мэргэжил	Тоо
1	Нягтлан бодогч, эдийн засагч	19
2	Хууль эрх зүйч	6
3	Төрийн удирдлага	2
4	Нийгмийн ажилтан	2
5	Бусад	5
6	Бүрэн дунд	3
Нийт		37

Нийт ажилтнуудын төрийн албанд ажилласан дундаж жил: 12 жил 2 сар
Нийгмийн даатгалын салбарт ажилласан дундаж жил: 7 жил 6 сар
Нийгмийн даатгалын улсын байцаагчийн зэрэгтэй: 16 улсын байцаагчтай
Үүнээс: Тэргүүлэх мэргэшлийн зэрэгтэй 3 албан хаагч
Зөвлөх мэргэшлийн зэрэгтэй 9 албан хаагч тус тус ажиллаж байна.

№	Ажлын байрны нэр	Тоо	Тайлбар
1	Нийгмийн хамгааллын хяналтын	1	МХГазраас ирсэн албан хаагч шилжин ажилласан. Орон тоог ТАЗ-н салбар зөвлөлөөр 6 удаа зарлуулсан.
2	Хүний нөөц, хуулийн мэргэжилтэн	1	Шинэ бүтцээр нэмэгдсэн орон тоо
3	Гурванбаян тосгоны нийгмийн даатгалын байцаагч	1	Сул орон тоог 2023 оноос 3 удаа зарласан. Өмнөдэлгэр сумын нийгмийн даатгалын байцаагч түр орлон гүйцэтгэгч

4	Галшар сумын нийгмийн даатгалын байцаагч	1	2024-02 сараас Татварын хэлтэст шилжин ажилласан. Хяналтын байцаагч түр орлон гүйцэтгэгч
5	Бор-Өндөр сумын нийгмийн даатгалын тасгийн байцаагч	1	2023 оноос сул орон тоог зарласан.
6	Дадал сумын нийгмийн даатгалын байцаагч	1	2024-10 сараас өөрийн хүсэлтээр ажлаас гарсан. Сул орон тоог зарлаж байна.
7	Цэнхэрмандал сумын нийгмийн даатгалын байцаагч	1	Жирэмсэн амаржсаны чөлөө авсан
8	Баянхутаг сумын нийгмийн даатгалын байцаагч	1	Жирэмсэн амаржсаны чөлөө авсан

Сул байгаа орон тоо

Биеийн эрүүл мэндийн байдлаас 3 сар ба түүнээс дээш хугацаагаар чөлөө авсан 1 албан хаагч, жирэмсэн амаржсаны чөлөөтэй 3 албан хаагч, тус тус байна.

Тайлант хугацаанд нийт албан хаагчдад 829668472.18 төгрөгийн цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг олгож хувь хүний орлогын албан татварт 79543925.3 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 184484467.79 төгрөгийг тус тус төлөөд байна. Газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнд аудитын шалгалт хийхэд Аудитын газраас ЗӨРЧИЛГҮЙ дүгнэлт авсан.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт болон нөхөн даатгалын лавлагааны хүсэлтийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын able программ, албаны мэйлээр хүлээн авч хариуг ажлын 3 хоногийн дотор гарган өгч хэвшээд байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус газарт 562 иргэнээс лавлагааны хүсэлт ирж, 533 иргэн, байгууллагад нийгмийн даатгалын төрөлжсөн архивын лавлагааг олгосон байна. Архивын лавлагаа цахимжин, аймаг, дүүрэг, сум хооронд Able программ ашиглан ажилласнаар даатгуулагчдад чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилгээ үзүүлдэг.

Төрийн архивын 2024 онд нөхөн бүрдүүлэлтээр байгууллагуудаас баримт хүлээн авах хуваариар тус газар энэ оны 4 дүгээр улиралд багтаан баримтаа тушаана. 1991-2015 оны байнга хадгалах 300 гаруй хадгаламжийн нэгжийг 2800 гаруй түр хадгалах хадгаламжийн нэгжийн цаасан болон цахим хэлбэрээр, батлагдсан данс бүртгэлийн хамт аймгийн Төрийн архивын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссоор батлуулахаар өгөх ажлыг зохих заавар журамд нийцүүлэн хийж байнга, түр хадгалах хадгаламжийн нэгжийн данс, бүртгэл болон боловсон хүчний хувийн хэргийн бүртгэл, устгах хэргийн актыг үйлдэн ажлаа эхлүүлэн нягтлан шалгалтын ажил эхлүүлээд байна. Одоогоор түр хадгалах 2500 гаруй хадгаламжийн нэгжид иж бүрэн нягтлан шалгалт хийж баримт тус бүрийг хадгалах хугацааны жагсаалтаар ангилж тоо бүртгэлийн ажлыг зохих зааврын дагуу хийж эхлээд байна. Байнгын хадгалалтад баримт шилжүүлэх ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна.

2024 оны 05, 06 сард тэтгэвэр авагчдын зогсоогдсон хувийн хэргийн бодит тоог тогтоон, цахим болон цаасан бүртгэлтэй болгож, хадгалалт хамгаалалтыг

сайжруулсан. Шаардлагатай тохиолдолд албан хаагчид зогсоогдсон хувийн хэргээс тэтгэвэр авагчийн мэдээллийг харах болон бичиг баримтаа авах иргэдэд цаг алдахгүй түргэн шуурхай үйлчлэх боломжийг бүрдүүлэн ажилласан. Тэтгэврийн хувийн хэргийг төрөл тус бүрээр нь ангилан зогсоогдсон он, овог нэр, харьяа сумаар нь тодорхойлон бичиж өндөр настны 8313, тэжээгчээ алдсаны 1300, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчийн 5131 зэрэг нийт 14744 хувийн хэргийг бүртгэж 380 хамгаалалтын хайрцагт хийн сан хөмрөгт зааврын дагуу байрлуулсан.

Өмнө нь



Дараа нь



Тус аймгийн 21 сум, тосгоны нийгмийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой тухайн ондоо хөтлөгдөж дууссан хэргийг хадгаламжийн нэгж болгон бүрдүүлж дараа оны 1 сард нь нийгмийн даатгалын байцаагчаас хүлээн авдаг. Баримт бичиг нягтлан шалгах комиссын хэлэлцэн шийдвэрлээд “Архивын баримт хүлээн авах, шалгах хуваарь батлах тухай” тушаалаар сумдын болон газрын баримтыг 2024 оны 1-р улиралд багтаан өгөх хуваарь гаргадаг.

Хуваарьт заасан хугацааны дагуу 21 сумаас, аймгийн төвийн албан хаагчдаас нийт 279 хадгаламжийн нэгж хүлээн авч хяналт шалгалтын байцаагч нараар хянуулан, бүртгэл үйлдэн архивын баримтыг нөхөн бүрүүлж баяжилт хийсэн байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО

2024 онд нийгмийн даатгалын сангийн орлого 58793,5 сая төгрөг батлагдсанаас сангийн орлого 58898,9 сая төгрөг буюу 100,2 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 83,2-107,4 хувиар биелүүлэн ажилласан, 2024 оны байдлаар нийгмийн даатгалын санд 58898,9 сая төгрөгийн орлого хуримтлуулсан.

Сар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
1	3,552,27	2,958,23	83.2
2	7,289,61	6,530,37	90.0
3	12,073,28	11,519,66	95.4
4	16,150,71	16,035,00	99.3
5	20,609,13	20,731,18	101.0
6	25,745,61	25,838,60	100.4
7	29541,79	31486,78	106,6
8	33885,96	35740,53	105,5
9	38612,44	40825,30	105,7
10	43145,94	46359,55	107,4
11	47811,01	51183,70	107,1
12	58793,5	58898,9	100,2

Аймгийн Улсын бүртгэлийн газар, Татварын газартай хамтран шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж байгууллагын судалгаанд үндэслэн албан журмын даатгуулагчийн хамралтыг нэмэгдүүлэх чиглэлийг сумдын байцаагчдад өгсөн. Үйл ажиллагаа явуулдаг боловч нийгмийн даатгалд хамрагдаагүй 12 ажил олгогчийг илрүүлж, тайлан тооцоог хийсэн. Мөн 2024 оны байдлаар нийгмийн даатгалд шинээр 89 ажил олгогчийг нийгмийн даатгалд шинээр хамруулсан. Мөн албан журмын даатгуулагчийн тоог 286 даатгуулагчаар нэмэгдүүлэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан.

Сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
Тэтгэврийн даатгалын сан	49676,9	50064,0	100,8
Тэтгэмжийн даатгалын сан	4431,9	4630,9	104,5
ҮОМШӨ-ний даатгалын сан	3076,8	3076,8	100
Ажилгүйдлийн даатгалын сан	1607,9	1127,2	70
НИЙТ	58793,5	58898,9	100,2

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төлөвлөгөө 126253,6 сая төгрөгөөс 126253,6 сая төгрөгийн зарлагыг батлагдсан төсөвт багтаан сан тус бүрээр зориулалтын дагуу хэтрүүлэлгүй ажилласан. Нийт зардлын 90.2 хувийг тэтгэврийн

даатгалын сан эзэлж байна. 2024 оны байдлаар давхардсан тоогоор 164 гаруй мянган даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд нь тогтоон бүрэн олгож, тэтгэвэр авагч, даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг жигд, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэлээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага сан тус бүрээр

Сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	Хэтрэлт - Хэмнэлт+
Тэтгэврийн даатгалын сан	54,826.2	50,726.7	92.5	+4,099.5
Тэтгэмжийн даатгалын сан	2,963.4	2,149.5	72.5	+813.9
ҮОМШӨ-ний даатгалын сан	2,667.0	2,190.0	82.1	+477.0
Ажилгүйдлийн даатгалын сан	822.9	655.5	79.6	+167.4
НИЙТ	61,279.5	55,721.7	90.9	+5,557.8

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАГДАЛТ

Аймгийн Улсын бүртгэлийн газар, Татварын газартай хамтран шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж байгууллагын судалгаанд үндэслэн албан журмын даатгуулагчийн хамралтыг нэмэгдүүлэх чиглэлийг сумдын байцаагчдад өгсөн. Үйл ажиллагаа явуулдаг боловч нийгмийн даатгалд хамрагдаагүй 12 ажил олгогчийг илрүүлж, тайлан тооцоог хийсэн.

2024 оны байдлаар нийгмийн даатгалд шинээр **89** ажил олгогчийг нийгмийн даатгалд шинээр хамруулсан. Мөн албан журмын даатгуулагчийн тоог 286 даатгуулагчаар нэмэгдүүлэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан.

Нийт **4969** иргэн сайн дурын даатгал хамрагдсан байна. Үүнээс **835** даатгуулагч шинээр хамрагдсан. Сайн дурын даатгалд хамрагдсан малчдын тоо нийт **2286** бөгөөд шинээр **486** малчин хамрагдсан. 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн даатгалд нийт 876 даатгуулагч хамрагдсанаас шинээр **63** даатгуулагч хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхийг даатгалд шинээр **46** даатгуулагчийг хамруулан ажилласан.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН АВЛАГА

2023 оны жилийн эцсээр нийт 2980,7 сая төгрөгийн авлагатай гарсан. Оны эхний авлагаас 95.0% буюу 2823,9 сая төгрөгийг барагдуулсан байна. Үүнээс үлдэгдэл 156,8 сая төгрөг үлдээд байна. Урсгал авлага 850,1 сая төгрөгийн авлагатай гарахаар байна.

Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн албанд нийт 12 аж ахуй нэгжийн 118.6 сая төгрөгийн найдваргүй авлагыг шилжүүлж, 112,1 сая төгрөгийг барагдуулаад байна. Нийгмийн даатгалын шимтгэлээ хуулийн хугацаанд төлөөгүй 174 аж ахуй

нэгж байгууллагын 1158,5 сая төгрөгт дансны хаалт хийж, 1100,1 сая төгрөгийг татан авсан, Хэнтий аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 15 аж ахуй нэгжийн 97,6 сая төгрөгийн авлага барагдуулах нэхэмжлэл гарган нэхэмжлэлийн шаардлагыг хангуулаад байна. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогод эзлэх хувь 1,4 байна

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН



Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа 13667 тэтгэвэр авагчид 113910,1 сая төгрөг зарцуулсан байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, жилийн эцсийн байдлаар тэтгэвэр шинээр тогтоолгосон 688 үүнээс өндөр насны тэтгэвэр 491, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр 131, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 66 тэтгэвэр авагч байна.

Шилжиж ирсэн нийт 20 үүнээс өндөр насны тэтгэвэр 14, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр 5, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 1, байна. Шилжиж явсан нийт 82 үүнээс өндөр насны тэтгэвэр-76, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр 3, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 3, тэтгэвэр авагч байна. Мөн тэтгэврээ өөрчлөн тогтоолгох нийт 691 хүнээс өндөр насны тэтгэвэр 122, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр 457, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 112, тэтгэвэр авагч байна.

Тэтгэвэр шинээр болон өөрчлөн тогтоолгохоор хүсэлт гаргасан мөн шилжиж ирсэн иргэдийн баримт бичгийг нягтлан шалгаж, үндэслэлийг хянан шалгаж, дарааллын дагуу мэдээллийн баазад бүртгэн тэтгэврийг үнэн зөв тогтоож, хяналтаар оруулан баталгаажуулж, зөрүү тэтгэврийн дүн үүссэн тохиолдолд тухай бүрд нь олголтыг хийж ажиллаж байна.

Манай газар нь энэ онд НДЕГазар ХААН, ХАС, Төрийн банктай байгуулсан хамтран ажиллах ерөнхий гэрээний дагуу хэрэгжилтийг ханган ажилласан. 2024 оны жилийн эцсийн тэтгэвэр олголтын файлыг сарын ажлын сүүлийн өдрийн 10 цагаас өмнө харилцагч банкнуудад цахимаар хүргүүлэн файл хүлээлцсэн акт үйлдэж сар бүрийн 01-нд тэтгэврийг олгож хэвшээд байна.

Банкнуудад тэтгэвэр тавьж олгосон үйлчилгээний хөлсийг тарифаар бодож ХААН банканд 5,9 сая төгрөг, Төрийн банканд 2,6 сая төгрөг, Голомт банк 0,02 сая төгрөгийг шилжүүлсэн.

Хүснэгт. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Тэтгэврийн төрөл	Суурь түвшин буюу 2023 оны мөн үе	Хүрсэн түвшин буюу 2024 он
------------------	-----------------------------------	----------------------------

	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
Өндөр насны	10231	70376,1	11352	99116,7
Хөдөлмөрийн чадвараа алдсаны	1544	8194,6	1507	7262,1
Тэжээгчээ алдсаны	579	3265,4	545	3280,8
Цэргийн	267	3212,3	263	4250,5
НИЙТ	12621	85048,4	13667	113910,1

ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН



Тэтгэмжийн даатгалын сангаас **2331** даатгуулагчдад **5023,0** сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгов. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад **793,5** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт . Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)


Тэтгэмжийн төрөл	Суурь түвшин буюу 2023 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2024 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан оны хагас жил хөрөнгө
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	3821	850,3	1912	1266,9
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	1065	2173,6	742	2967,1
Оршуулгын тэтгэмж	368	736,0	161	789,0
НИЙТ	5254	3759,8	2815	5023,0



3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд үлдсэн 50 хувийг даатгуулсан эсэхээс хамаарч тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс олгохоор шийдвэрлэсэн хуулийн хүрээнд 876 эхчүүдтэй гэрээ байгуулж тэтгэмжийн даатгалын сангаас 325,1 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангийн орлогод төвлөрүүлэн ажиллаа.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН

ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САН



ҮОМШӨ-ний даатгалын сангаас 502 тэтгэвэр, тэтгэмж авагчдад нийт 5445,6 сая төгрөгийг зарцуулсан байна.галын сангаас **584** тэтгэвэр, тэтгэмж авагчдад нийт **2,189.2** сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Зардлын төрөл	Суурь түвшин буюу 2023 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2024 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
ҮОМШӨ-ний тэтгэвэр	399	3555,5	409	5033,8
ҮОМШӨ-ний тэтгэмж, төлбөр	137	87,6	93	144,9
Тахир дутуу иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэл	347	218,6	354	266,9
НИЙТ	867	3861,7	856	5445,6

АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН



Ажилгүйдлийн даатгалын сангаас 508 даатгуулагчид ажлаас халагдсаны тэтгэмжид 1530,4 сая төгрөг зарцуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 227,7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Зардлын төрөл	Суурь түвшин буюу 2023 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2023 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
Ажилгүйдлийн тэтгэмж	467	1302,7	508	1530,4

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Нийгмийн даатгалын газрын Захиргаа, хяналтын хэлтэс нь Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журамд заасан эрх үүргийн хүрээнд хяналт шалгалт хийх, аливаа хууль бус үйлдлийг таслан зогсоох, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх, дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийн хүрээнд ажиллаа.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Захиргаа хяналтын хэлтсийн 2024 онд хийх хяналт, шалгалтын төлөвлөгөөг газрын даргаар батлуулан, нийгмийн даатгалын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар чиглэлийн дагуу дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дархан, Баянмөнх сумын төсөвт байгууллагуудын 2022-2023 оны санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримтад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Шалгалтаар давхардсан тоогоор 93 даатгуулагчийн 50.4 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод 11.9 сая төгрөгийн шимтгэл ногдуулан хугацаа хэтрүүлсэн хоногт 5.9 сая төгрөгийн алданги тооцон улсын байцаагчийн акт үйлдэн нийт 17.8 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн 10 байгууллагын албан тоот, хүсэлтийн дагуу улсын байцаагчийн акт үйлдэн нийт 0.87 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлснийг төлүүлэхээр шийдвэрлэсэн. Дотоодын хяналт шалгалтын явцад илэрсэн өндөр насны 2 тэтгэвэр авагчийн 7.2 сая төгрөгийн тэтгэвэр илүү олгосон зөрчил илэрч, нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг удирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэн тайлан мэдээг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хооронд Хамтран ажиллах санамж бичгийн дагуу Хэнтий аймгийн Дадал сумын хилийн цэргийн 0287 дугаар ангитай байгуулсан санамж бичгийн хүрээнд 2021-2024 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг холбогдох баримтад үндэслэн шалгасан. Шалгалтаар улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагчийн ажилгүй байгаа эхнэр, нөхөр, жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй байгаа цэргийн алба хаагч эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг ирүүлсэн жагсаалтын дагуу шалган үзэхэд 20 даатгуулагчийн төрлийг буруу сонгон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тусгасан зөрчил, 2024 оны 07 дугаар сарын 15-ний өдрийн 03/105 тоот албан бичгийн хавсралтын дагуу улсын хил дээр алба хааж байгаа цэргийн алба хаасны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосны дараа цэргийн цолтой ажилласан, 2 цэргийн алба хаагчийг энгийнээр бүртгэсэн зэрэг зөрчил илэрсэн. Тус санамж бичгийн хүрээнд Хилийн цэргийн 0287 дугаар ангийн 20 даатгуулагчтай холбоотой 2814565 төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлж, 2 даатгуулагчид холбоотой 1901416 төгрөгийн илүү төлсөн шимтгэлийг дараа сард суутган тооцохоор, илэрсэн зөрчлийг залруулах арга хэмжээ авч ажилласан.

БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вэбсайт хуудсанд бүрэн байршуулах ажил системийн хэмжээнд хангалтгүй үнэлэгдсэн. Засгийн газраас байгууллагын нээлттэй мэдээллийг үнэн зөв, ил тод байршуулсан эсэхэд хяналт тавьж, үнэлгээ өгөх Shilen.gov.mn цахим хуудсыг нэвтрүүлсэн байна. Тус газар нь дээрх цахим хуудсанд мэдээлэл байршуулан, хяналт тавин ажиллах албан хаагчийг тушаалаар томилон хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн хяналт тавин ажиллах чиг үүрэг бүхий албан хаагчийг томилон хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Удирдлагын зүгээс Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн холбогдох зүйл заалтад заасан мэдээллийг Shilen.gov.mn, аймгийн албан ёсны вэбсайт www.khentii.mn, нийгмийн даатгалын газрын веб сайтад хуулийн хугацаанд байршуулах, хийсэн ажлын тайланг холбогдох газарт хүргүүлэхийг цахим хуудсанд мэдээлэл байршуулан ажиллах албан хаагчид чиглэл өгөн ажиллаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх удирдамжийн дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2024 оны 01 дүгээр сарын 03-05-ны өдрийн хооронд дотоод аудитын ажлыг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, шилэн дансны цахим хуудасны 2023 оны хөтлөлт, тайлан мэдээ байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг оруулсан эсэхэд үнэлгээ өгч, гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэл өгч ажилласан. Шилэн дансны мэдээллийг цахим системд тухай бүр, хуулийн хугацаанд тайлагнаж байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 139 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлснээс 138, хугацаа хоцорч мэдээлснээс 1 мэдээ байна. Нийгмийн даатгалын сантай холбоотой 130 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлснээс 124, хугацаа хоцорч мэдээлснээс 6 мэдээ байна. Энэ нь 1-дүгээр улирлаар 2 мэдээлэл буруу оруулснаас болж засварлах үйлдэл хийсэн тул хугацаа хоцорсон байна. Мөн 3 дугаар улирлын байдлаар хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй боловч нийгмийн даатгалын сангийн 5 саяас дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээг дутуу оруулсан зөрчил гарсныг тухай бүр залруулан ажилласан. 2024 онд НДЕГ-аас ирүүлсэн чиглэл, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ийн дагуу шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, мэдээллийн үнэн зөв, бүрэн байршуулсан эсэхэд улирал бүр хяналт тавих ажлыг Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтэстэй хамтран хийж гүйцэтгэж байна.

ЦАХИМ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб программ”-аас 2020 онд 7, 2021 онд 105, 2022 онд 42, 2023 онд 96 даатгуулагчийн төрлийг буруу тайлагнасан зөрчил илэрч, 2020-2023 онд нийтдээ давхардсан тоогоор 250 даатгуулагчтай холбоотой зөрчил илэрсэн. Эдгээр даатгуулагчдыг шалган үзэхэд 44 байгууллагатай холбоотой 50 даатгуулагчийн 786.2 мянган төгрөгийн илүү төлсөн шимтгэл, 2600.1 мянган төгрөгийн дутуу төлсөн шимтгэлийн зөрчил илрүүлэн барагдуулах арга хэмжээ авч ажилласан. Цахим хяналтын хүрээнд хяналт, шалгалтыг 2023 оныг дуустал хугацаанд сар бүр тогтмол хийж ажилласан. Цахим хяналтын программаар шүүгдэж байгаа нийт алдааны 70 орчим хувь нь зөрчлийн шинжгүй алдаа байгаа бөгөөд шийдвэрлэх боломжтой алдааг анхан шатны баримтад тулгуурлан тухай бүр Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтэс, Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэстэй хамтран залруулан ажилласан.

НИЙГЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тус газрын хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь 2024 оны санхүүгийн жилд Нийгмийн хамгааллын байцаагчгүйгээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод хяналт шалгалт хийх төлөвлөгөөнд тусгагдаагүй мөн хийгээгүй болно. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор баталсан "Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө"-ний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13-07/08 дугаартай "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021- 2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтын хэрэгжилтийг шалгасан. Шалгалтаар 107.3 сая төгрөгийн улсын байцаагчийн акт үйлдэн, 74.1 сая төгрөгийг барагдуулан, 33.2 сая төгрөгийн төлбөр зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

ДОТООДЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

2024 оны жилийн эцсийн байдлаар шинээр 688 тэтгэвэр тогтоогдсон. Үүнээс өндөр насны 491, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 131, тэжээгчээ алдсаны 66 тэтгэвэр тогтоогдож хянагдсан байна. Мөн шилжиж ирсэн 20 тэтгэвэр, шилжиж явсан 82 тэтгэврийг баазад оруулж мэдээллийн баазын бүрдлийг ханган ажилласан байна. Шүүхийн шийдвэр болон улсын байцаагчийн актын дагуу суутгал хийгдэж байгаа 11 тэтгэврийг сар бүр суутгал хийн холбогдох дансанд шилжүүлж байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа сунгасан, жилийн нэмэгдэл хийлгэсэн 510 тэтгэвэр авагчийн мэдээллийг хянан баталгаажуулсан. Тэтгэвэр авах эрхийн харилцаа дууссан нас барсан, зогсоогдсон 517 тэтгэвэр авагчийн

олголтын тооцоог хийж хувийн хэргийг хянан архивд шилжүүлсэн байна. НДЕГ-ын даргын 2024.05.29-ний 01/1107 албан бичгийн дагуу тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг шалган үзсэн. Шалгалтаар 14664 тэтгэвэр, тэтгэмж авагчийн олголтыг шалган үзэхэд 169 тэтгэвэр авагчид 39.9 сая төгрөгийг илүү олгосон зөрчил илэрч, 37.3 сая төгрөгийн төлбөр зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулан барагдуулсан. Дотоодын хяналт шалгалтаар сайн дурын даатгалд хамрагдах гэрээ байгуулан сайн дурын даатгалын шимтгэл төлж байгаа 27 даатгуулагчийн өргөдлийн дагуу гомдол мэдээллийг шалгаж, залруулгын акт үйлдэн, мэдээллийн баазад засвар хийж зөрчлийг арилган ажилласан. Мөн 2022-2023 оны сайн дурын даатгалын хамралт, шимтгэл ногдуулалт, мэдээллийн баазын баяжилт, хуулийн хэрэгжилтийг шалгах дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2022 онд Хэрлэн суманд хамрагдсан даатгуулагчдын мөнгө төлсөн баримт, харилцахын программ, гэрээтэй тулган шалгахад, алданги дутуу төлсөн болон төлөөгүй 48 даатгуулагчийн 0.7 сая төгрөгийг нөхөн төлүүлэх, ажил олгогчтой давхардсан болон алданги илүү төлсөн 7 даатгуулагчийн 0.4 сая төгрөгийг буцаан олгохоор ажилласан байна. Тайлант хугацааны дотоодын хяналт, шалгалтын төлбөр зөрчлийн эхний үлдэгдэл 38.1 сая төгрөг байсан ба шинээр шалгаж илрүүлсэн 7.2 сая төгрөгийн төлбөр зөрчил нэмэгдэж, нийт 45.4 сая төгрөг болсон. Үүнээс 18.4 сая төгрөгийг барагдуулан ажилласан байна.

МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Маргаан Хянан Шийдвэрлэх Салбар Зөвлөл нь 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. 2024 оны нийт 14 даатгуулагчийн өргөдлийн дагуу 7 удаа хуралдаж 5 даатгуулагчид нөхцөл хангасан шийдвэр, 6 даатгуулагчийн малчин жил тогтоож, 3 өргөдлийг буцааж дахин баримт бүрдүүлэх шийдвэр гаргасан байна. Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл нь ирсэн өргөдлийн баримт бүрдэлд дүн шинжилгээ хийж зөвлөлийн гишүүдийн санал дүгнэлт нь дээр үндэслэн шийдвэрийг гаргаж ажиллаж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛ.

2023 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалттай 2673 иргэн хамрагдаж байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалттай 2791 иргэн хамрагдсан байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар 44 удаа эрүүл мэндийн магадлалын зөвлөл хуралдсан.

Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссоос тэтгэвэр авч байгаа нийт 2775 иргэнээс 2151 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгасан бол үүнээс сунгалтаар 1528, хувь бууруулсан сунгалтаар 1858, хивэндээ сунгагдсан 1290, шинээр 281, цуцлагдсан 117, буцаагдсан 285, шилжиж явсан 16, шилжиж ирсэн 8 иргэний асуудлыг ту тус хянан шийдвэрлэсэн. Буцаагдсан 285 иргэдийг


дахин үзлэг шинжилгээнд хамруулж, 200 иргэнд бичиг баримтын үзлэг шинжилгээ хийж, 25 иргэнтэй өөрийн биеэр уулзаж хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаанд сунгалт хийж, 10 иргэнийг 3 дугаар шатлалын эмнэлэг рүү шилжүүлэн ажиллаж байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд эрүүл мэндийн үзүүлэлттэй харьцуулан дүн шинжилгээ хийхэд өмнөх жилийнхээс өвчлөл ихэссэн. Одоогийн байдлаарх судалгаанаас авч үзэхэд өвчний заалтууд шинэчлэгдэж гэмтэл, мэс засал, дотор, чих хамар хоолой, хавдрын өвчнүүд шинээр ихэссэнтэй холбоотой байна.



Эрүүл мэндийн хөдөлмөр магадлалын комиссын мэргэжилтэн эмч нар өвчний мэргэжлийн дагуу болон бусад өвчнийг хуваарилан авч сумдын болон өрх аймгийн эмч нартай хамтран эмчлэн эдгэрүүлэх төлөвлөгөөг гарган хөдөлмөрийн чадварыг сэргээн засах тусламж үйлчилгээний талаар байгууллагуудад заавар зөвлөгөө өгч ажиллаа.

Эрүүл мэндийн байгууллагуудад сэргээн засах тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, талаар албан тоот болон зөвлөмж хүргүүлж ажилласан. Үүний дагуу нэгдсэн эмнэлэгт сэргээн засах эмчилгээний тасгийг 20 ортой болгож өргөжүүлэн ажиллаж байна. Гэмтэл болон мэдрэлийн чиглэлээр ордог иргэдийг жилд сэргээн засах тасагт 1 удаа хэвтэн эмчлүүлэх мөн 2—3 удаа өдрийн болон амбулаторийн үйлчилгээг авч байх шаардлага тавьж ажиллаж байна. Хавдрын өвчний хүнд шатанд болон гэрийн асаргаанд байх боломжгүй өвчтөнийг хавдрын хөнгөвчлөх тасагт 5 өвчтөнийг хэвтүүлэн эмчлүүлж сувилуулсан.



Сумдын хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хамтран ажиллаж холбогдох мэдээ тайлан, зөвлөгөө зөвлөмж, мэдээллийг гарган өгч ажилласан. Үүнд Баянмөнх сумын их эмч Батцэцэг эмч сумынхаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргүүлэгчээр ажилладаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэйгээ хамгийн ойр хамтарч ажилладаг нь бусад сумд санаа авч ажиллах сайхан туршлага боллоо. Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хамтарч зөвлөгөөн уулзалт зохион байгууллаа.



Эрүүл мэндийн магадлалын мэдээллийн сан:

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим мэдээллийн сангийн бүрдэлд хөдөлмөр, халамжийн үйлчилгээний мэргэжилтэн, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр мэдээллийн цахим санг хувийн хэрэгтэй тулган шалгах хяналт, шалгалтыг ажлыг 2 удаа хийсэн.

Шалгалтаар:

- 2023 оны жилийн эцсийн тоон мэдээллээс шалгаж 2024 оны эхэнд дараах хөдөлгөөнийг хийж ажилласан.
- нас барсан 8, шилжсэн 3, Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 5, цуцлагдсан 5 нийт 21 иргэний мэдээллийг цахим санд хөдөлгөөн хийлгүй орхисон зөрчлийг илрүүлэн мэдээллийн баазад залруулан, хөдөлгөөнийг оруулан зөрчлийг арилгасан.
- Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран хаягийн бүртгэлийн мэдээллийг шалган үзэхэд: Улаанбаатарын харьяат – 15, Налайх дүүргийн -1, Багахангай дүүргийн -1, Дорноговь аймгийн -1, Дорнод аймгийн-1 иргэн байсныг илрүүлэн эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн баазад шилжих хөдөлгөөн оруулан зөрчлийг арилгасан.


Эрүүл мэндийн магадлалын Зөвлөлийн программд 2 даатгуулагчийн овог, нэр зөрсөн байсныг тулган шалгаж эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн программд зөрчлийг арилган засварласан. Нийт нас барсан 37 байсан нас барсан 1 иргэний мэдээллийг Улсын бүртгэлийн хэлтсээс тодруулан шалгуулж зөрчлийг арилгаж ажилласан мөн Улаанбаатарын харьяатай 1 иргэнийг Баянзүрх дүүрэг, налайх дүүрэгт шилжүүлсэн. Хөдөлмөрийн чадвар алдалтын эмнэлгийн хувийн хэргийг цахимаар солилцох боломжтой болсон. Баянзүрх дүүрэгт шилжсэн – 2 иргэний хувийн хэргийн материалыг мэйлээр явуулж шийдвэрлэсэн.

2024 онд улсын бүртгэлийн хэлтэс болон эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн санд 2 дахь удаагийн тулгалтаар хугацаагүй заалттай иргэдээс харьяаллын дагуу зөрчилтэй 13 иргэнийг шалгаж шилжүүлэв. Харьяа газрын магадлагч эмч болон ах дүү өөртэй нь холбоо тогтоосон мөн хугацаатай заалттай иргэдээс 2 хүнийг шилжүүлэв. Бусад иргэдийн материалыг мэйл хаягаар болон шуудангаар магадлагч эмч нарт явууллаа. Орхон Баян-өндөр – Ш.Ханджамц ЛЮ93062108 дотор /тэжээгчээ алдсан ээж нь шилжих боломжгүй байна бага насны хүүхэд асран халамжилдаг төрсөн ээж нь олддоггүй/ учраас шилжилт хөдөлгөөн хийгдэх боломжгүй байна.

СУРГАЛТ – ЗӨВЛӨГӨӨН:


“Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт

батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны А/441, А/192-р тушаал, “Журам, маягтын загвар батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны А/177 А/443-р тушаал, Засгийн газрын 2023 оны 448-р тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж Эрүүл мэндийн газартай хамтарч 15 сумын 40 эмч мэргэжилтнүүдэд сургалтыг зохион байгуулж ажилласан.



Үйлдвэрлэлийн осол хурц хордлогоос урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдлын сарын аяны хугацаанд урьдчилан сэргийлэх арга хэмжээг Нэгдсэн эмнэлгийн ажилчид, сумдын эрүүл мэндийн ажилчид, эвт худалдааны төвийн ажилчдад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сургалт мэдээлэл өгч сургалтын материалыг тарааж ажилласан.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Хүний эрхийн хороотой хамтарч төрийн байгууллагын хүний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүдэд иргэдийн танхимд болон халамж үйлчилгээний төвд сургалт зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал шийдвэрлүүлэх зүүн бүсийн уулзалтад оролцож “Хэнтий аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн байдал”-ын талаар төрийн болон төрийн бус байгууллагын удирдлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 48 төлөөлөлд мэдээ, мэдээллийг хүргэн ажилласан.



Дорнод аймагт болсон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/15 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд,

хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход оролцож байгаа анхан шатны эмч нарыг чадавхжуулах нь” сэдэвт бүсчилсэн сургалтад оролцсон.



ДОТООД АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТАЛААР:

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн эмч нартай хамтарч дотоод хяналтыг эрчимжүүлэх зорилгоор иргэдийн ирсэн сунгалтын картад хяналтыг 7 хоног бүрийн 3 дахь өдрийн хурлаар хамтран хийж зөвөлгөө өгөх ба цахим мэдээллээр дамжуулан мэдээ мэдээллийг өгч байна.


Хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд эрүүл мэндийн үзүүлэлттэй харьцуулан дүн шинжилгээ хийхэд тэргүүлэх өвчнөөр сэтгэц – 543, дотор -459, мэс,гэмтэл- 436, мэдрэл – 426, нүд - 338 болсон нь өмнөх жилийнхээс нэмэгдсэн дүгнэлт гарсан. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөс 2024 онд даатгуулагч, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсалтын дагуу мэргэжлийн багаас бүрдсэн эмч нарын сургалтыг цахимаар 6 удаа хийж сургалтад хурлын 5 эмч, 3 мэргэжилтэн, 6 удаа оролцсон зэргээр мэргэжилтнүүдийн мэдлэгийг сайжруулах тал дээр анхаарч ажилласан. Эмчлэн эдгэрүүлэх төлөвлөгөө боловсруулж, сэргээн засах тасгийн эрхлэгч Хатанбаатар эмчтэй хамтран ажиллаж бариа засал, гадна зүү төөнүүр, хөдөлгөөн засал, татлага эмчилгээ, физик эмчилгээнд хамруулсан. Үүнд 458 гаруй иргэдийг уламжлалт үзлэгт хамруулж, 78 иргэнийг хэвтэн эмчлүүлээд байна.



СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ

ДОТООДЫН СУРГАЛТ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын чанар хүртээмж, хамралтыг сайжруулах зорилгоор ажил олгогч, даатгуулагч болон ажилтнуудыг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулахад анхаарч ажиллаа. Тухайлбал:




Мэргэшүүлэх сургалтыг дотооддоо Нийгмийн даатгалын ерөнхий газар болон хэлтэс, орон нутгийн байгууллагаас зохион байгуулсан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх 44 удаагийн цахим болон танхимын сургалтад давхардсан тоогоор 840 албан хаагчдыг хамруулсан.

Үүний дотор: “Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 вебинар” 10 удаагийн сургалтад давхардсан тоогоор 643 албан хаагч хамруулсан.




➤ 2024.01.12 ны өдөр НДЕГ-аас зохион байгуулсан “Цахим мэдээллийн цаг”-ийг “Хүн амын орлогын албан татварын тухай хууль, тайлан гаргахад анхаарах асуудал”-ы талаар сургалтад газрын 26 алба хаагч хамрагдсан.

➤ 2024.01.19 ны өдөр “ХАСХОМ мэдүүлэх нь” сэдэвт сургалтад газрын 26 алба хаагчид бүрэн хамрагдсан.




➤ 2024.01.22 ны өдөр Sicos системийн талаарх сургалтад газрын 26 алба хаагчид бүрэн хамрагдсан.

➤ 2024.02.20 ны өдөр "Ажил олгогчийн тайлангийн систем" -ийн танилцуулга сургалтад цахимаар ОШТ-ийн дарга, Орлого шимтгэлийн байцаагч, ХШТ-ийн дарга, Хяналт шалгалтын байцаагч, Үйл ажиллагааны нягтлан, Мэдээллийн технологийн мэргэжилтэн нар хамрагдсан.



ХНХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга танилцуулга сургалтад газрын 25 алба хаагч хамрагдсан.

➤ 2023.03.15-ны өглөө 08:30 цагийн "Мэдээллийн цаг"-аар "Донорын төв"-ийн эмч Алтантулга "Донорын тухай хууль, хуулийн хэрэгжилт", "Оршуулгын тэтгэмж, амьгүй донор менежмент" сэдвээр мэдээлэл өглөө. Тус сургалтад газрын тэтгэмжийн байцаагч болон магадлах эмч нар цахимаар оролцсон.



➤ 2024.04.08 "хөдөлмөрийн аюулгүй байдал- эрүүл ахуйн сарын аян-2024" хүрээнд хийгдэж буй цахим сургалтад тус газрын 27 алба хаагч хамрагдсан.

➤ 2024.04.15 “Цахимд хэвшье “DIGITAL FIRST - 01” Сургалтад тус газрын дарга Н.Нямхатан, МТмэргэжилтэн Б.Баярсайхан нар хамрагдсан.



Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл мөн “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд тус газрын ажилтан, албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх, хууль сурталчлах, мэдээлэл өгөх, зөвлөн туслах үйлчилгээг идэвхжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулснаар нийт 36 албан хаагч хамрагдсан болно. Тус сургалтад НДЕГазрын 2 сургалт цахимаар, Аймгийн ЗДТГазраас “Авлига, Авлигын хор хөнөөл” сэдвээр, Аймгийн НТБТөвөөс “Суралцагч байгууллагын манлайлал” сэдвүүдээр хамтарсан сургалт зохион байгууллаа. Мөн сумдын байцаагч нарын дунд “Би нийгмийн даатгалын байцаагч” эсээ бичлэгийн уралдаан, Спортын арга хэмжээг зохион байгуулж 1,2,3 дугаар байрыг шалгаруулсан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024.10.24-ны өдрийн 05/2196 албан тоотын дагуу Улсын байцаагчийн шалгалтанд бэлдэх байцаагч нарыг 2024.10.28-2024.11.06-ны өдрүүдэд сургалтанд 10 байцаагчийг цахимаар хамрагдсан байна. Үүнээс 4 байцаагч сумын НДБайцаагч хамрагдсан.

Улсын Онцгой байдлын газар, НДЕГазраас зохион байгуулсан , Аймгийн онцгой байдлын газраас зохион байгуулсан “Гамшгийн үед авах арга хэмжээ” сургалтыг 2024.11.01, 2024.11.08-ны өдрүүдэд 2 удаагийн сургалтаар давтагдсан тоогоор 63 албан хаагч цахимаар болон танхимаар хамрагдсан байна.

Аймгийн Цахим хөгжлийн хэлтэсээс зохион байгуулсан Монгол улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдлын өнөөгийн нөхцөл байдал, Цахим гэмт хэргээс урьдчилан сэргэлэх нь сургалтанд 2024.10.29-нд 31 албан хаагч цахимаар болон танхимаар хамруулсан.

ГАДАГШАА ЧИГЭЛСЭН СУРГАЛТ.

Ажил олгогч даатгуулагчдад чиглэсэн сургалтыг оны эхнээс төлөвлөгөө гарган хэлтсийн даргаар батлуулан хагас жилийн байдлаар 244 удаагийн сургалтаар 19630 иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ач холбогдол,

нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт, мэдээлэл хүргэн ажилласан.


ААН албан байгууллага, иргэд даатгуулагчид чиглэсэн сургалтын хүрээнд 126 удаагийн сургалт уулзалт хийсэн. 9902 иргэд, даатгуулагчид сургалт, уулзалтад хамрагдаад байна.



Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэд, малчдад чиглэсэн сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх 118 удаагийн сургалт хийсэн. 9728 иргэд даатгуулагч сургалтад хамрагдсан.



➤ www.hentii.ndaatgal.mn вэб сайт, www.facebook.com/NDKHenti фэйсбүүк, “Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар” фэйж хуудсаар 111 мэдээлэл, постер оруулж мөн ХНХЯам, НДЕГзраас бэлтгэсэн сурталчилгаа, мэдээ, мэдээллийг цахим сүлжээ ашиглан олон нийтэд түгээсэн ба давхардсан тоогоор 256 мянга гаруй иргэд даатгуулагчдад хүрсэн байна.



Нийт албан хаагчид НДЕГ-ын @sigomongolia фэйсбүүк хуудсыг дагаж, мэдээлэл авах, мэдээллийг цааш түгээх ажлыг гарын алба хаагчид болон сумын байцаагчид 31 албан хаагч НДЕГ-ын фэйсбүүк хуудсыг дагаж, мэдээллийг цааш түгээн ажилласан.

Нийгмийн даатгал “ЦАХИМ ХӨТӨЧТЭЙ”-тэй боллоо. Цахим хөтчийг нэвтрүүлсэн талаар пост мэдээллийг газрын фэйж хуудас болон аймаг сумын группүүдэд мэдээллэж түгээж танилцуулж ажиллаж байна.

Нээлттэй мэдээллийн сарын хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Сайн дурын даатгалын талаар 3 удаагийн live дамжуулалт хийж хийт 36 мянган хүний хандалт авсан байна. Мөн бид танхимаар ирж оролцох боломжгүй буюу Сумдын төсөвт газар болон ААНэгжүүдийн нягтлан бодогч нарт зориулсан “Нийгмийн даатгалын сангаас олгогдох тэтгэмж, Эмнэлгийн хуудас илгээх заавар” сэдвээр Zoom уулзалтыг зохин байгууллаа. Үүнд нийт 4 удаагийн цахим уулзалтыг 246 газрын нягтлан бодогчид хамрагдсан. Мөн тэдэнд илгээлтэй холбоотой тулгамдсан асуултуудад хариулт зөвлөгөө өгсөн. Цахим хуудас болон албан хаагчдыг идэвхижүүлэх зорилгоор “Бурмаар тэтгэхээр, Урмаар тэтгэ”, “Дэм дэмдээ”, “Зам цэвэр бол автомашинд амгалан, Даатгалаа төлсөн бол амьдралд амгалан” зэрэг контентуудыг хийж гүйцэтгэсэн байна.

“Нийгмийн даатгалын тухай багц хууль” тогтоомжийг сурталчлах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, нийгмийн даатгалын ач холбогдлын талаар мэдээ мэдээлэл өгөх зорилгоор өдөрлөгийг 2024 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнд Захиргаа, хяналтын хэлтсийн дарга, Орлого шимтгэлийн байцаагч, Хяналтын байцаагч, Тэтгэврийн байцаагч, Архивч, Сургалт сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн гэсэн бүрэлдэхүүнтэй зохион байгуулан ажиллалаа. Өдөрлөгөөр Сайн дурын даатгалын ач холбогдолыг таниулах, Нийгмийн

даатгалын апплейкишн /NDAATGAL2.0/ шинэчилж суулгах, тэтгэврийн тогтоолгоход бүрдүүлэх материал, тэтгэвэр тогтоолгох болзол, нөхцөл, ХЧА, ЖА тэтгэмж цахимаар илгээх, ажилгүйдлийн тэтгэмжийн материал цахимаар илгээх, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны захиалга авах, 2000 оноос хойшх шимтгэл төлөлтийн лавлагааг шууд гаргаж гэсэн үйлчилгээнүүдийг үзүүлж, иргэд даатгуулагчдаас санал асуулга авах ажлыг зохион байгууллаа. Өдөрлөгөөр нийт 620 иргэд даатгуулагчид зөвлөлгөө үйлчилгээ авсан.

"Нээлттэй мэдээлэлийн сар"-ын хүрээнд Хэнтий аймгийн төвийн багууд,Төвийн олон нийт хөдөлгөөн ихтэй гудамж талбай, Хүнс барааны дэлгүүрүүдэд 29 удаа "Явуулын үйлчилгээ"-г зохион байгуулсан. Мөн аймгийн ЗДТГазартай хамтран сумдад 18 удаа, "Явуулын үйлчилгээ"-г явуулж нийт 47 удаагийн 2311 иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын багц хуулийн мэдээ мэдээлэл өгч 5 сангийн гарын авлагыг тараасан байна.



ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ХҮРЭЭНД

Нэг цэгийн заалны үйлчилгээг өргөтгөж иргэд даатгуулагчдад үйлчлэх тав тухтай нөхцөлийг бүрдүүлж, үйлчлүүлэгчидтэй нэг түвшнээс харьцах, хөгжих таатай орчин бүрдүүлж ажиллаж байна. Мөн Төрийн албан хаагчаас иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй, хүнд суртал гаргахгүй, хөнгөн шуурхай үйлчилгээг нэвтрүүлэх үүднээс Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газраас үнэлгээний төхөөрөмжийг суурилуулсан. Үнэлгээний төхөөрөмжийн мэдээг сар болгоны 25-нд Аймгийн засаг даргын тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна.


1. Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан Хэнтий аймгийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Асуудлаас-Шийдэлд" тэмцээнийг зохион байгуулсан. Тус газар нь 1 ажилтны нийгмийн асуудлыг сайжруулах, 2 ажилтныг газартай болгох, иргэд даатгуулагчдад үйлчилдэг заалны орчин нөхцөл тав тухыг сайжруулж иргэдийн

сэтгэл ханамж нэмэгдүүлэх 3 зорилт тавин оролцсон. Уг уралдаанд 39 төрийн байгууллага шалгарсанаас нийлбэр дүнгээр гутгаар байрыг эзэлсэн.

“Асуудлаас-Шийдэлд” уралдааны шагнал 5 сая төгрөгөөр ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор албан хаагчдаас санал авсаны үндсэн дээр сандал, хөшиг авахаар шийдвэрлэсэн.

2. Асуудлаас шийдэлд, төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг нэг цэгээс хөнгөн шуурхай хүргэх, зорилгоор тус байгууллагат киоск машин байршуулсанаар нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийн тодорхойлолт, тэтгэврийн эрх үүсээгүй тодорхойлолт, нэрийн дансны лавлагаа гэх мэт 18 төрлийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай авах боломж бүрдсэн.

3. Иргэд даатгуулагчдад ил тод нээлттэй байх үүднээс байгууллагын албан хаагчдын танилцуулга, үйл ажиллагааны мэдээллийг цахим хэлбэрээр хүргэх үүднээс нэг давхрын үйлчилгээний зааланд 80 инчийн цахим тооцоолуур бүхий дэлгэцийг байршуулсан байна.



ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР